


УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



Улаангом-Хандгайт чиглэлийн авто замаас Сагил сум чиглэлийн 5.6 км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах даалгавар

2024.04.11

Дугаар: 28/2024

Улаангом

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8.1.2. дахь заалт - Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.6.1.6., 3.6.1.8. дахь заалт
2	Захиалагч байгууллага	Эдийн засаг, хөгжлийн яам, Увс аймгийн Засаг даргын тамгын газар
3	Зураг төслийн нэр, Байршил	Улаангом-Хандгайт чиглэлийн авто замаас Сагил сум чиглэлийн 5.6 км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ, зураг төсөл
4	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
5	Зураг төсөв зохиох үе шат хугацаа	Нэг үе шаттай.
6	Гүйцэтгэгч /Шаардагдах тусгай зөвшөөрөл/	Авто замын зураг төсвийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийг тендер шалгаруулах зарчмаар сонгон шалгаруулна.
7	Боловсруулах хугацаа	2024-2026 он
8	Гүйцэтгэх ажлууд	Зураг төслийг одоогоор мөрдөгдөж буй хууль, норм ба дүрэм, стандартуудыг баримтлан боловсруулах. Эскиз зураг төслийг одоогоор мөрдөгдөж буй барилгын норм дүрэм, стандартуудыг баримтлан захиалагчийн хүсэлтийн дагуу боловсруулан батлуулсаны дараа ажлын зургийг гүйцэтгэн магадлалаар батлуулж, захиалагчид хүлээлгэн өгөх. Хатуу хучилттай авто замын зураг төсөлд дараах: <ul style="list-style-type: none">- Замын трассын дагуу 2 км тутамд хатуу цэгийг тогтоож, стандартын дагуу бэхлэх, геодезийн хэмжилтийг UTM системд хийж гүйцэтгэх- Зам гүүрний зурваст орсон болон доогуур хөндлөн өнгөрч байгаа инженерийн байгууламж, цахилгаан, холбооны шугам сүлжээний техникийн нөхцөлийг холбогдох байгууллагаас авах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, засварлах, өндөрсгөх ажлын тоо хэмжээ, зардлыг тооцож зураг төсөлд тусгах,- Замын зурваст археологийн тандалт, судалгаа хийх, авран хамгаалах малталт хийлгэх ажлын хэмжээ, өртгийн төсөвт тусгах,- Шаардлагатай хэсгүүдийг тодорхойлж мал амьтан гарах гарц төлөвлөх,- Ухмал ба зам дээр цас хунгарлахаас сэргийлэх далангийн шийдлийг төсөллөх,

		<ul style="list-style-type: none"> - Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох, - Хөдөлгөөний аюулгүй байдлын дүгнэлт гаргах, тэмдэг тэмдэгжилтийн талаар холбогдох байгууллагаас санал авах, замын хөдөлгөөнийг зохион байгуулах техник хэрэгсэл тоноглолыг оновчтой төлөвлөх - Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж зураг төсөвт тусгах, - Тээврийн хэрэгслийн зогсоол амрах байгууламжийг холбогдох стандартын дагуу төсөллөж тусгах, - Инженер геологийн судалгаа хийж хэсэг бүрд хөрсний геотехникийн үзүүлэлтийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох, хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох, - Геофизик, геологийн судалгаагаар /чулуу бэлтгэх, ачих тээвэрлэх/ намгархаг газрын газар шорооны ажлын тоо хэмжээг төсөвт суулгах, судалгаагаар үерийн усны хамгаалалтын далан хийгдэх бол төсөвт суулгах, - Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах,
9	Зураг төслийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> - Авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл - 2% - Тайлбар бичиг - 2% - Техникийн шаардлага - 2% - Инженер геодезийн тайлан - 2% - Инженер геологийн судалгааны тайлан - 2% - Хяналтын төсөв - 2% - Магадлалын дүгнэлтүүд - Ус зайлуулах байгууламжуудыг /пикет болон нэмэлт пикетээр/ хүснэгтээр ирүүлэх - 2% - Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ – 2% - Цахим хэлбэрээр /PDF, дэвсгэр зураг dwg/ - 1%
10	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан, холбох хууль, норм ба дүрмийг мөрдлөг болгох. - Авто замын ажлын зурагт Монгол улсад мөрдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016, "Авто зам, гүүрийн төсөл хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30-01-04, "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНБД 32-02-12 норм ба дүрмийг мөрдөх. - Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох. - Инженер геодезийн хэмжилт байр зүйн зураглалын ажилд "Авто зам болон төмөр замын геодезийн ажил" БД 11-114-14 норм дүрмийг мөрдлөг болгон улсын сүлжээний

		<p>цэгүүдэд тулгуурлан хийх, геодези байр зүйн зураглалын тайланг боловсруулах.</p> <ul style="list-style-type: none"> - “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зураг төсөл зохиох заавар” БД 31-112-11 норм стандартын шаардлага хангасан байхаар төлөвлөх. - Авто замын эхлэлийг тухайн орон нутгийн ЗДТГ болон орон нутгийн зам, засвар арчлалтын байгууллагатай зөвшилцөж захиалагчид танилцуулах - Трассыг сонгохдоо сумдын удирдлага, холбогдох орон нутгийн удирдлагын саналыг тусгаж төсөллөх, - Замын трасс болон хучилтын хийцийг сонгохдоо төслийн бүсэд байгаа бусад үйлдвэр, уурхайн бүтээгдэхүүний болон бүс орон нутгийн авто тээврийн хэрэгсэл зорчих хөдөлгөөний урсгалыг тооцох, - Ажлын нэр төрөл, тоо хэмжээ барилгын ажлын төсөв-техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний болон захиалагчийн хяналтын зардлыг тусгах
--	--	--

Хянасан:

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга

Б.Баттогтох

Аймгийн ГХБХБГ-ын дарга

С.Нямжав

Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга

Б.Батболд

Боловсруулсан:

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэргэжилтэн

Б.Мөнхбаяр

